

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Энэхүү урьдчилсан тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

“Геодези” гэдэг нь дэлхийн хэлбэр, хэмжээ, түүний гадаргын шилжих хөдөлгөөнийг тодорхойлох, газрын гадаргын хэсгийг зураг болгон буулган дүрслэх зорилгоор од, нар, хиймэл дагуул болон газрын зургийн багаж хэрэгслийн тусламжтайгаар тухайн цэгийн байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг хэмжин тодорхойлж математик боловсруулалт хийх цогцолбор үйл ажиллагаа юм.

“Зураг зүй” гэдэг нь газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцаа хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг тоон болон дүрслэлийн аргаар зохиож хэвлэх үйл ажиллагаа юм.

Геодези, зураг зүйн үйл ажиллагаа нь дээрх тодорхойлолтуудаас шинжлэх ухааны үндэслэл, тооцоотойгоор хийгддэг нарийн мэргэжлийн үйл ажиллагаа болох нь харагдаж байна.

Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үр дүнд улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай байр зүйн зураг, тоон мэдээллийг бүрдүүлдэг.

Энэ үйл ажиллагааг олон улсын хэмжээнд ижилхэн арга, техник, технологи ашиглан явуулдаг бөгөөд манай улсын хувьд ч олон улсын жишигт нийцсэн геодезийн сүлжээ байгуулан ажиллахыг зорьж байна.

Гэвч одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Геодези, зураг зүйн тухай хууль 1997 онд батлагдсан бөгөөд цаг хугацаа, зохицуулах харилцааны хувьд ихээхэн хоцроод байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Геодези, зураг зүйн тухай хууль нь 3 бүлэг, 15 зүйл, 123 заалттай ба зүйл, заалт бүрээр дүн шинжилгээ хийж тухайн зүйл, заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгарч буй асуудал, өөрчлөх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тулгарч буй асуудал, өөрчлөх хэрэгцээ, шаардлагын талаар 21 аймаг, нийслэл, дүүргийн Газрын албанаас санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан ба ирүүлсэн санал, хэлэлцүүлгийн үр дүнд дүн шинжилгээ хийж нэгтгэн хуулиар зохицуулаагүй асуудлыг шинээр зохицуулах шаардлага тулгараад байна. Хуулиар зохицуулаагүй асуудлыг Хавсралт 1-т үзүүлэв.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Тулгамдаж байгаа асуудлуудын мөн чанар, цар хүрээг тоймлон тодорхойлбол:

1. Геодези, зураг зүйн талаарх хууль тогтоомжийн бүрэн цогц байдал алдагдсан байна. Тухайлбал: Хуульд 1999 оноос эхлээд өнөөг хүртэл нийтдээ 9 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 16 зүйл, 41 хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж, 2 хэсэг /3-аас дээш заалттай/ шинээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль батлагдсантай холбоотойгоор 1999 онд хуулийн 3.1.9, 4.1.9 дэх заалтыг тус тус өөрчлөн найруулсан.

- Мэргэжлийн хяналтын байгууллага бий болсонтой холбоотойгоор 2000 онд хуулийн 8.2 дахь хэсгийг өөрчилж, 5.4.7 дахь заалтыг хүчингүй болгосон.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбоотой 2001 онд хуулийн 6 дугаар зүйлд 3 заалт бүхий 6.2 дахь хэсгийг нэмж, 5.4.4, 6.1.1 дэх заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, 12.1.1 дэх заалт, 14.2 дахь хэсгийг өөрчлөн найруулж, 5.2.2 дахь заалтыг хүчингүй болгосон.

- Улс төрийн сонгуулийн үр дүнд Засгийн газар шинээр эмхлэгдэн байгуулагдсан тул холбогдох бусад байгууллагуудын нэр өөрчлөгдсөн, түүнчлэн Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Улсын геодези, зураг зүйн газар, Эрхийн улсын бүртгэлийн газар, Газрын хэрэг эрхлэх газар гэсэн 3 байгууллагыг нэгтгэж Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар болгосонтой холбоотойгоор 2003 онд хуулийн 7.1, 9.2, 5.4. 7.2, 9.3, 10.2, 10.3, 11.1, 11.2 дахь хэсэг, 5.6.2, 5.6.3, 5.7.2, 9.4.1, 10.4.4, 12.1.1 дэх заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, 10.4.3 дахь заалтыг өөрчлөн найруулж, 5.3, 9.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосон.

- Барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг хэрэгжүүлэгч агентлаг болгосонтой холбоотойгоор 2005 онд хуулийн 5 дугаар зүйлд 6 заалт бүхий 5.4 дэх хэсгийг нэмж, 5.6.2, 5.6.3, 7.2, 12.1.1, 5.4.1 дэх заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, 5.4.3, 5.4.4, 5.4.6 дахь заалтуудыг тус тус хүчингүй болгосон. Мөн заалтуудын дугаарлалтыг өөрчилсөн.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан 2011 онд хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосон.

- Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор 2015 онд хуулийн 14 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан.

- Зэвсэгт хүчний тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан хуулийн 5.6 дахь хэсгийг өөрчилсөн.

- Гамшгаас хамгаалах тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор 2017 онд хуулийн 4.1.10 дахь заалтыг өөрчилсөн.

Энэ нь тухайн хуулийн нийт 123 заалтын 30 хувьд өөрчлөлт орсон гэсэн үг бөгөөд дээр дээр дурдсанчлан шинжлэх ухааны үндэслэл, тооцоотойгоор хийгддэг

нарийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, бодлогыг тодорхойлсон хуулийг бусад салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон эсвэл шинэчлэн найруулсан тухай бүрд өөрчилж байгаа нь агуулгын хувьд хуулийн 1 дүгээр зүйлд заасан үндсэн зорилтоо хангаж чадахааргүй байдалд хүргээд байна.

2.Одоогийн мөрдөгдөж байгаа хуульд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тодорхойлоогүй, геодези, зураг зүйн бүтээгдэхүүнийг бүх салбар суурь болгон ашиглан үйл ажиллагаа явуулдаг байхад одоогийн мөрдөгдөж байгаа хууль нь зөвхөн геодези, зураг зүйн салбарын үйл ажиллагааг зохицуулж бусад салбарт хийгдэж, ашиглаж байгаа газрын зураг, хэмжилт зураглалын ажил нь өнөөг хүртэл хуулийн зохицуулалтгүй явагдаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллага нь нэгдсэн тогтолцоонд шилжиж төрийн хяналтыг гүйцэтгэж байгаа бөгөөд бүх салбарт хийгдэж, ашиглагдаж байгаа геодези, зураг зүйн хэмжилт, зураглалын ажилд төрийн хяналт тавих бүтэц орон тооны хувьд хангалттай биш байна.

Геодези, зураг зүйн бүтээгдэхүүн ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйл ажиллагаанд хөндлөнгийн /магадлал /хяналт хийх зохицуулалтгүй байна.

3. Геодези, зураг зүйн салбар нь улсын хилийг тодотгон тогтоох, нутаг дэвсгэрийн хэмжээг болон түүн дээрх бүхий л объектуудыг газрын гадаргын нөхцөл байдалд нь геодезийн өндөр нарийвчлал бүхий хэмжил зүйгээр орон зайн харилцан байршлаар зураглаж, байрлалд суурилсан орон зайн болон байрзүй, газрын зургийн тоон мэдээллээр байгаль орчин, хөдөө аж ахуй, хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай зэрэг нийгэм эдийн засгийн бүхий л салбаруудыг хангадаг, батлан хамгаалах аюулгүй байдалд голлох үүрэгтэй улс орны хөгжлийн суурь салбар юм.

Гэтэл салбарын институци болон үйлдвэрлэл, үйл ажиллагааны, ажил үйлчилгээний зориулалт, түүний төрөл, ангиллыг хуульчлаагүй байна.

4. Геодези, зураг зүйн салбарын гол бүтээгдэхүүн газрын зураг, түүнд хамаарах тоон мэдээллийг тухай бүр шинэчлэн геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэн хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангаж байх шаардлагатай байдаг. Гэтэл байгаль орчин, батлан хамгаалах, геологи, уул уурхай, дэд бүтцийн салбарт улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төслийн хөрөнгөөр болон иргэн, хуулийн этгээдийн захиалгаар гүйцэтгэсэн геодези, зураг зүйн бүтээгдэхүүнийг улсын нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх зохицуулалт байхгүй байна.

Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн нь олон зорилго, зориулалтаар ашиглаж болох суурь ажил, үйлчилгээ байдаг бөгөөд тэр ч үүднээс нэгдсэн нэг сан /төрийн архив/-д архивлахаар хуульчилсан байдаг. Гэвч анхнаасаа тухайн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг захиалах, төсөвлөх хэрэгжүүлэх үйл ажиллагаа, мэдээллийн сангийн нэгдсэн биш, төрийн байгууллагуудын геодези, зураг зүйн чиглэлээрх үйл ажиллагаа харилцан уялдаагүй байгаагаас ажил давхардаж хийгдэх, давхардсан хөрөнгө оруулалт хийгдэх зэрэг асуудлууд гарсаар байна. Жишээлбэл: нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /ГЗБГЗЗГ/-аас тоон хэлбэрт оруулсан байхад Геологийн төв лаборатори, Байгаль орчны мэдээллийн төв зэрэг байгууллагууд тус тусдаа тоон хэлбэрт оруулж өөрийн үйл ажиллагаандаа ашигласан. Өөрөөр хэлбэл нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100000-ны

масштабтай байр зүйн зургийг тоон хэлбэрт оруулахад улсын төсвөөс 3 өөр шугамаар 3 удаа мөнгө гаргасан байна. Мөн геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /ГЗБГЗЗГ/-аас нийслэл, аймаг, сум, суурингийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг тоон хэлбэрээр хийж мэдээллийн сан үүсгэх ажил хийгдсэн.

Мөн орон нутагт газар зохион байгуулалт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг шинээр болон дахин төлөвлөх үед 1:500–ны масштабтай дэвсгэр зураг шинээр хийж байгаа боловч геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд нэгтгэж оруулж чадахгүй байна. Нөгөө талаас аймаг, нийслэл сум, суурин газар 1:1000-ны масштабтай байр зүйн болон дэвсгэр зураг хийгдэж, дээрх ажилд төлөвлөлт хийхэд ашиглах 1:500-ны зураг хуучирч ашиглах боломжгүй болсон. Иймд 1:500-ны масштабтай дэвсгэр зургийг шинэчилж, мэдээллийн санд оруулдаг болгох шаардлагатай байна.

5. Хуулиар зохицуулагдаагүй, зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлуудыг хавсралт 1-т урьдчилсан байдлаар тодорхойлов. Тухайлбал: улсын геодезийн сүлжээ байгуулах, байр зүйн зураглалын асуудлыг хуульчилж тэдгээрийн шинэчлэлт өөрчлөлтийг нэгдсэн бодлоготойгоор хийх, төрийн захиргааны байгууллагуудад хариуцуулах асуудлыг тусгах шаардлагатай.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд:

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэн, төрийн бус байгууллага Геодези, зураг зүйн салбарын төрийн бус байгууллага нь геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, геодези, зураг зүйн салбарын эрх ашгийг хамгаалах чиглэлээр зохицуулалт байхгүй байна.
2	Төр /нийтийн эрх ашиг/ Төрийн байгууллагуудаас геодези, зураг зүйн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг захиалах, төсөвлөх хэрэгжүүлэх, ашиглах үйл ажиллагаа нэгдсэн биш байгууллагууд тус тусдаа мэдээллийн сан үүсгэсэн, тэдгээрт хадгалагдаж буй ижил төрлийн мэдээлэл нь хоорондоо зөрдөг, ийм мэдээллээр үйлчилгээ үзүүлдэг буюу газрын зургийн үнэн зөв байдал алдагдсан, салбар бүр өөрт шаардлагатай байгаа газрын зургийг тус тусдаа давхардаж хийлгэдэг, давхардсан хөрөнгө оруулалт хийгдэх зэрэг асуудлууд гарсаар байна. Газрын зураг нь өдөр бүр өөрчлөгдөж, шинэчлэгдэж байх онцлогтой бөгөөд иргэн, хуулийн этгээдийн захиалгаар хийсэн газрын зургийг мэдээллийн нэгдсэн санд оруулах тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна.
3	Бусад байгууллага 1. Батлан хамгаалах, иргэний зориулалттай геодези, зураг зүйг ялган тодорхойлоогүйгээс геодезийн үйл ажиллагаа зөвхөн батлан хамгаалах зориулалттай мэтээр ойлгох явдал газар авсан. Үүнээс төрийн нууцын асуудал хөндөгдөж, геодезийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг нийтэд нь төрийн нууцад хавтгайруулан хамруулсан, газрын зураг, тоон мэдээлэл ашиглахад төрийн зүгээс иргэн, хуулийн этгээдүүдэд хязгаарлалт хийгдсэнээс үйл ажиллагаанд нь хүндрэл бий болсон. 2. Чанарын шаардлага хангаагүй геодези, зураг зүйн бүтээгдэхүүн газрын зураг, тоон мэдээлэл ашигласнаас байгаль орчин, геологи, уул уурхайн салбарт нөөцийн тооцоо дутуу хийгддэг, дэд бүтцийн бүх салбарт ажлын хэмжээ дутуу тооцоологдож улмаар тухайн ажлыг чанаргүй гүйцэтгэх болон эдийн засгийн хохирол үүсэх шалтгаан болж байна.

		<p>3. Дэд бүтцийн бүх салбар, байгаль орчин, геологи, уул уурхайн салбарт гүйцэтгэж байгаа ажлуудын суурь нь төрөл бүрийн масштабын байг зүйн зургууд байдаг хэдий ч геодези, зураг зүйн хэмжилт, зураглалын ажлын өртгийг тусгадаггүйн улмаас тэдгээрийг өөр зургаар орлуулах эсвэл хямд өртгөөр чанаргүй гүйцэтгүүлэх зэрэг эрсдэлийг бий болгож байна.</p> <p>4. Геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, газрын зураг тоон мэдээг ашиглан боловсруулж байгаа бүтээгдэхүүнд үүсэх эрсдэлийг урьчилан тооцоолох магадлалын ажил бүх салбарт огт хийгдээгүй байна.</p>
--	--	--

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дараах зорилгуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, ажил үйлчилгээ эрхэлж байгаа асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бусад төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх эрх, үүргийг тодорхой болгох, геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн ашигласан ажил, үйлчилгээнд магадлал хийх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бий болгох;

2. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйл ажиллагаа бүтээгдэхүүн, ажлын хамрах хүрээ, зориулалт, түүний төрөл, ангиллыг тодорхой болгох;

3. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, ажлыг төлөвлөх, захиалах, төсөв тооцох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дараалал, мэдээллийн сангийн асуудлыг хуульчлах;

4. Хуулиар зохицуулагдаагүй, зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлыг зохицуулах.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг талыг хүснэгт 1-ээр үзүүлэв.

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
<p>1. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бусад төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн геодези, зураг зүйн чиглэлээр гүйцэтгэх эрх, үүргийг тодорхой болгох, геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн ашиглан зохиогдсон төсөл, ажилд магадлал хийх эрх зүйн орчныг бий болгох.</p>			

1	Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Интервенци хийж шийдвэрлэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах эрхийг хуулиар олгогдоогүй тул боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн бус байгууллага, иргэн хуулийн этгээдийн гүйцэтгэх эрх, үүргийг тодорхой болгох, геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн ашиглан зохиогдсон ажил, үйлчилгээнд магадлал хийх эрх зүйн орчныг бий болгох.	Зардал үр өгөөж тулгамдаад байгаа асуудал нь хуулиар зохицуулагдан.	Үр дүнтэй
2. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүн, ажлын хамрах хүрээ, зориулалт, түүний төрөл, ангилалыг тодорхой болгох;				
1	Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Интервенци хийж шийдвэрлэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах эрхийг хуулиар олгогдоогүй тул боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	1.Ажлын давхардал, давхардсан хөрөнгө оруулалтаас зайлсхийхийн тулд бусад яам, агентлаг, орон нутаг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг зураглахдаа геодези, зураг зүйн ажил урьд өмнө нь хийгдэж байсан эсэхийг мэдээллийн сангаас нягтлах,	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд эдийн засгийн хувьд хэмнэлттэй, төрийн үйлчилгээ иргэдэд хурдан шуурхай хүрэх нөхцөл бүрдэнэ.	Үр дүнтэй

		улсын хэмжээнд хийгдсэн геодези, зураг зүйн ажлын мэдээллээр сан үүсгэх, хийх гэж буй ажлыг технологийн дарааллын дагуу гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ. 2.УИХ хурал, Засгийн газар, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд, монгол улсад үйл ажиллагаа эрхлэж байгаа олон улсын байгууллагууд, иргэд, хуулийн этгээд геодези, зураг зүйн баталгаатай, шинэ, бүтээгдэхүүн ашиглах нөхцөл бүрдэнэ.		
3. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг төлөвлөх, захиалах, төсөв тооцох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дараалал, мэдээллийн сангийн асуудлыг хуульчлах;				
1	Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Интервенци хийж шийдвэрлэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагаас холбогдох журам, норм дүрмийг батлан мөрдүүлэх боломжтой.	Нэмэлт зардал гарахгүй боловч журам батлах талаар тусгайлан эрх олгосон заалт хуульд нэмэлтээр оруулах шаардлагатай.	Тодорхой үр дүнд хүрнэ.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй газрын зураг түүнд холбоотой бусад мэдээллүүдийг геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөгт тогтмол нэгтгэж баяжуулснаар, байнгын шинэчлэлтийг тогтмол хийснээр шийдвэр гаргагчдыг бодит цаг хугацааны үнэн бодит мэдээллээр хангах, газар зохион байгуулалт, зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, уул уурхай, байгаль орчин, хөдөө аж ахуй зэрэг дэд бүтцийн салбаруудад улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлын давхардсан хөрөнгө оруулалтыг зогсоох, нийтийн хэрэгцээний газрын зураг,	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд эдийн засгийн хувьд хэмнэлттэй, төрийн үйлчилгээ иргэдэд хурдан шуурхай хүрэх нөхцөл бүрдэнэ.	Үр дүнтэй

		түүний тоон мэдээллээр үйлчлэх тогтолцоо бүрдэнэ.		
4. Хуулиар зохицуулагдаагүй, зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлыг зохицуулах.				
1	Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Интервенци хийж шийдвэрлэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах эрхийг хуулиар олгогдоогүй тул боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Үр дүнгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зохицуулагдаагүй харилцаанууд бүрэн зохицуулагдаж, геодези, зураг зүйн салбар олон улсын жишигт хүрч хөгжих нөхцлийг бүрдүүлнэ.		Үр дүнтэй

Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд асуудлыг шийдвэрлэх зорилгыг хангахад Хууль тогтоомжийн төсөл боловсруулах гэсэн зохицуулалтын хувилбарыг сонгов.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт /2, 3, 4, 5/-ээс үзнэ үү.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулан батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаврыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Геодези, зураг зүйн тухай хуулийг батлахдаа Оросын хуулийг орчуулан боловсруулж, батлуулсан байдаг. Иймд манай геодези, зураг зүйн салбарын эрх зүйн орчин, тогтолцоо ОХУ-тай адилхан юм. ОХУ 2016 онд Геодези, зураг зүй болон орон зайн өгөгдлийн тухай хуулиа шинэчлэн баталсан бөгөөд уг хуулийг орчуулан судалж харьцууллаа. Мөн агуулга, бүтцийн хувьд ОХУ, БНХАУ, Япон улсын хуулиудтай харьцуулан хавсралт 2-т үзүүлэв.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Өнөөдрийн тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийг цогцоор шийдвэрлэх боломжийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар хангахаар байна.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Үгүй	Тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш
	1.2. Оролцоог хангах		
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага		
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй

3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Үгүй	Эрх агуулагч байхгүй
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Эрх агуулагч байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	Эрх агуулагч байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Үгүй	Эрх агуулагч байхгүй
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Хамааралгүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө, хамаарал байхгүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадварт ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулахгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгохгүй
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэхгүй
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавихгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал гарахгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Одоо байгаа бүтэц зохион байгуулалт хэвээр байна.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Одоо байгаа бүтэц зохион байгуулалт хэвээр байна.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Олон улсын туршилгыг нэвтрүүлэхтэй холбоотой шинэ техник технологи нэвтэрнэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Давхардсан үйл ажиллагаа, мэдээллийн сангийн асуудал цэгцэрнэ. Дундын мэдээллийн сантай болсноор иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Давхардсан үйл ажиллагаа, мэдээллийн сангийн асуудал цэгцэрнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
-------------------	---------------------	---------	---------

1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Тусгай хамгаалалттай газрын бүртгэл, мэдээлэл сайжирч нэгж талбарт суурилсан кадастрын мэдээллийн системд нэгтгэгдэнэ.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Иргэн, аж ахуйн нэгжид олгогдсоноос бусад газар төрийн өмчид бүртгэгдэж кадастрын нэгдсэн мэдээллийн системд орно.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилалд өөрчлөлт орвол ангилал өөрчлөгдөх асуудал гарч болзошгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАЛААРХ УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА

№	Зүйл, заалт	Тухайн зүйл, заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгарч буй асуудал, өөрчлөх хэрэгцээ, шаардлага	Шийдвэрлэх арга зам, зүйл, заалтыг өөрчлөн найруулах, өөрчлөх санал /томъёолол/
	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл		
	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт		
1.	1.1. Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.		
	2 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж		
2.	2.1. Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж нь энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.		
3.	2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.		
	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо		
4.	3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:		
5.	3.1.1. "геодези" гэж дэлхийн хэлбэр, хэмжээ, түүний гадаргын шилжих хөдөлгөөнийг тодорхойлох, газрын гадаргын хэсгийг зураг болгон буулган дүрслэх зорилгоор од, нар, хиймэл дагуул болон газрын зургийн багаж хэрэгслийн тусламжтайгаар тухайн цэгийн байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг хэмжин тодорхойлж математик боловсруулалт хийх цогцолбор үйл ажиллагааг;		
6.	3.1.2. "зураг зүй" гэж газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцаа хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг тоон болон дүрслэлийн аргаар зохиож хэвлэх үйл ажиллагааг;		
7.	3.1.3. "газрын зураг" гэж газрын гадаргын бодит зүйлийг хавтгайд тодорхой тусгаг, масштабт оруулан томъёолсон тэмдгээр дүрсэлснийг;		
8.	3.1.4. "зурагжуулах" гэж төрөл бүрийн масштабтай байр зүйн болон бусад зургаар эх дэлхийн тодорхой хэсгийг дүрслэх цогцолбор үйл ажиллагааг;		
9.	3.1.5. "газар зүйн нэр" гэж газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор тогтоосон нэрийг;		

10.	3.1.6. "геодезийн байнгын цэг, тэмдэгт" гэж геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газрын гадарга, хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн төв болон түүний гаднах тэмдэглээсийг;		
11.	3.1.7."геодезийн сүлжээ" гэж геодезийн байнгын цэг, тэмдэгтүүдийн тогтолцоог;		
12.	3.1.8. "геодези, зураг зүйн багаж хэрэгсэл" гэж өнцөг, өндөр, зай, хүндийн хүчний хурдатгал болон цэгийн байрлалыг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр тодорхойлох багажийг;		
13.	3.1.9. "кадастрын зураг" гэж газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгө, газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад шаардагдах дэвсгэр зураг зохиох, газрын зургийн мэдээллээр геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг бүрдүүлэх зорилготой хийсэн бусад зургийг.		
		Нэмэлтээр оруулах	"байр зүйн зураг" гэж газрын гадарга, түүний махиаг тооцон, бодит зүйлсийг нарийвчлан дүрсэлж, тусгайлсан таних тэмдгээр тэмдэглэж, мөн чанарыг нь илэрхийлсэн газрын зургийг;
	Хоёрдугаар бүлэг.		
	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг		
	4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа		
14.	4.1. Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дараахь ажил хамаарна:		
15.	4.1.1. геодезийн сүлжээ байгуулах, одон орны тодорхойлолт, гравиметрийн хэмжилт хийх, төрөл бүрийн масштабын байр зүйн болон мөрөн, гол, нуурын ёроолын зураг үйлдэх, шинэчлэх, хэвлэх;		
16.	4.1.2. агаар, сансраас газрын зураг авах, боловсруулалт хийх;		
17.	4.1.3. төрөл бүрийн масштабтай тусгай зориулалт бүхий сэдэвчилсэн, сургалтын болон нийтийн хэрэгцээний газрын зураг зохиох, шинэчлэн хэвлэх;		
18.	4.1.4. хот, тосгон, бусад суурины газар доорх болон дээрх инженерийн байгууламж, ерөнхий төлөвлөгөө, тохижилтын дэвсгэр зураг хийх, шинэчлэх;		
19.	4.1.5. газар зүйн нэрийн жагсаалт (каталог) зохиож хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх;		
20.	4.1.6 дэлхийн хэлбэр, хэмжээ, газрын гадаргын хэвтээ, босоо хөдөлгөөнийг тодорхойлох, зайнаас тандан судлах зэрэг геодези, зураг зүйн эрдэм шинжилгээний судалгаа явуулах;		
21.	4.1.7. геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан бүрдүүлэх;		
22.	4.1.8. улсын хилийн шугамын байршлыг геодезийн аргаар тодорхойлох, шалгах;		
23.	4.1.9. газар, хот байгуулалт, инженерийн шугаман байгууламж, геологи, уул уурхайн болон бусад бүх төрлийн кадастрын зураг үйлдэх, инженер хайгуул, барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалтын үеийн геодезийн хэмжилт явуулах, өрөмдлөгийн цооног холбох;		

24.	4.1.10. улсын аюулгүй байдлыг хангах болон байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарах зэрэг нөхцөлд геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх.		
	5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг		
25.	5.1. Улсын Их Хурал геодези, зураг зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:		
26.	5.1.1. геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлогыг тодорхойлох;		
27.	5.1.2. улсын хилийн шугамын дагуух байр зүйн зураг, геодезийн аргаар тодорхойлогдсон хилийн тэмдгийн солбицол, өндрийг батлах;		
28.	5.1.3. газар зүйн нэрийг батлах;		
29.	5.1.4. 1:25000-аас багагүй масштабтай байр зүйн зурагт тэмдэглэгдсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зургийг батлах;		
30.	5.1.5. геодези, зураг зүйн тоон мэдээлэл, байр зүйн зургийн нууцын зэрэглэл тогтоох, нууцыг ил болгох.		
31.	5.2. Засгийн газар геодези, зураг зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:		
32.	5.2.1. геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог батлах;		
33.	5.2.3. олон улсын баримт бичигт тусгах, газрын зурагт хэрэглэгдэх Монгол Улсын газар зүйн нэр, улсын болон засаг захиргааны нэгжийн хилийн байршил, өөрчлөлтийн талаархи мэдээллийг холбогдох олон улсын байгууллагатай солилцох.		
			5.2.4. геодези, зураг зүйн үйл ажиллагааны журам батлах, мөрдүүлэх
			5.2.5. газар зүйн нэрийн бодлогын үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах,
34.	5.4. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:		
35.	5.4.1. геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;		
36.	5.4.2. геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;		
37.	5.4.3. Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;	Геодезийн бүх төрлийн сүлжээг өтгөрүүлэх, сайжруулах асуудал зурагжуулах бодлогын үндэс болно.	5.4.3. Монгол Улсын геодезийн бүх төрлийн сүлжээг өтгөрүүлэх, сайжруулах, нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;
38.	5.4.4. геодези, зураг зүйн заавар, дүрэм батлах, стандартыг боловсруулж мөрдүүлэх;	геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой заавар, журмыг геодези, зураг	5.4.4. энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгийг батлах;

		зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хамааруулах нь хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцнэ.	
39.	5.4.5.олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;		
40.	5.4.6.иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох.	Тусгай зөвшөөрөл цуцлах, түүнтэй холбоотой журам боловсруулах геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаа юм.	5.4.6. иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, түүнтэй холбоотой журам баталж мөрдүүлэх
41.	5.5. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нууцын зэрэглэлтэй материал үйлдвэрлэж, хадгалж байдгийн хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:		
42.	5.5.1. геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх;		
43.	5.5.2. геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг бүрдүүлэх;		
44.	5.5.5. геодези, зураг зүйн хэмжлийн багаж хэрэгслийг шалгах, баталгаажуулах;		
45.	5.5.8. нууцын зэрэглэлтэй зургийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, бүрэн бүтэн байдлыг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хянан шалгах;		
46.	5.5.9. төрөл бүрийн масштабтай байр зүйн болон дэвсгэр зургийг олгох, худалдах, шилжүүлэх, мэдээллээр хангах.		
47.	5.6. Зэвсэгт хүчний ерөнхий штаб цэргийн зориулалтаар хийж буй геодези, газрын зургийн ажилд хяналт тавина.		
48.	5.7. Төрийн захиргааны бусад төв байгууллага геодези, зураг зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:		
49.	5.7.1. геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжийн биелэлтийг харъяалсан салбартаа зохион байгуулах;		
50.	5.7.2. улсын захиалга, даалгавраар болон салбарынхаа хүрээнд хийх геодези, зураг зүйн ажлын дараа жилийн захиалгыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж өгөх;		
51.	5.7.3. өөрийн хэрэгжүүлж буй төслийн хөрөнгөөр хийгдэх геодези, зураг зүйн ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран сонгон шалгаруулалт (тендер)-ын журмаар явуулах.		
52.	5.8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга геодези, зураг зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:		
53.	5.8.1. геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;		
54.	5.8.2. нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах газар зүйн нэр, хил, шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын		

	талаархи мэдээлэл, геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж, жил бүр тооллого явуулж дүнг дараа жилийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлэх;		
55.	5.8.3. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн харьяа нутаг дэвсгэрт нь хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавих;		
56.	5.8.4. нутаг дэвсгэртээ хамаарах газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, шинэ нэрийн талаар санал дэвшүүлэх.		
	6 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үүрэг		
57.	6.1. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дараахь үүрэгтэй:		
58.	6.1.1. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан байх;		
59.	6.1.2. хэмжлийн багажиндаа баталгаажуулалт хийлгэх;		
60.	6.1.3. хэмжлийг солбицол, өндрийн улсын нэгдсэн тогтолцоонд хийх.		
61.	6.2. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, иргэн нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:		
62.	6.2.1. үйл ажиллагаандаа ашиглах хэмжилт, боловсруулалтын багаж хэрэгслийн жагсаалт, хувийн дугаар, гэрчилгээ;		
63.	6.2.2. мэргэжлийн боловсон хүчин болон тэдний дадлага туршлагын талаарх тодорхойлолт;		
64.	6.2.3. заавар, стандарт болон техникийн баримт бичгийн жагсаалт.		
	7 дугаар зүйл. Санхүүжилт		
65.	7.1. Улсын захиалга, даалгавраар хийх геодези, зураг зүйн ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ		
66.	7.2. Геодези, зураг зүйн улсын чанартай ажлын захиалагч нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд жил бүр улсын захиалга, даалгаврыг боловсруулж улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авна.		
67.	7.3. Салбар хоорондын болон орон нутгийн чанартай геодези, зураг зүйн ажлын захиалагч нь холбогдох төрийн захиргааны төв байгууллага байна.		
68.	7.4. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний захиалгаар хийгдэх геодези, зураг зүйн ажлыг захиалагчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.		
	8 дугаар зүйл. Геодези, зураг зүйн улсын хяналт		
69.	8.1. Геодези, зураг зүйн улсын хяналт нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, дүрмийн биелэлтийг хангана.		
70.	8.2. Геодези, зураг зүйн улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллагад болон аймаг, нийслэлд ажиллах геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ		

71.	8.3. Геодези, зураг зүйн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.		
	ГУРАВДУГААР БҮЛЭГ Бусад зүйл		
	9 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан		
72.	9.1. Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан /цаашид “нэгдсэн сан” гэх/ нь геодезийн сүлжээний, байр зүйн зургийн, агаар, сансрын зургийн, газар зүйн нэрийн болон кадастрын тухай мэдээлэл, тэдгээртэй холбогдох бусад тоон мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан нь төрийн өмч байна		
73.	9.2. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллага хэрэгжүүлж буй төслийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлынхаа тайлан, эх материал, солбицлын жагсаалт (каталог), бүдүүвч зураг, бичлэг, бусад тоон мэдээллийг нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлнэ.		
74.	9.3. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, бусад материалыг худалдан авч болно.		
75.	9.4. Нэгдсэн сан дараахь зүйлээс бүрдэнэ:		
76.	9.4.1. геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаа газрын зураг, хэвлэлийн эх, гэрэл зургийн хальс, тайлан, солбицолын жагсаалт (каталог), бусад тоон мэдээлэл;		
77.	9.4.2. энэ хуулийн 9.2-т заасны дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн материал;		
78.	9.4.3. бусдад худалдах, олшруулах эрхгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс худалдан авсан, энэ хуулийн 9.4.1, 9.4.2-т зааснаас бусад онц чухал материал;		
79.	9.4.4. байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс өөрсдийн үйл ажиллагаа, бүтээлийг сурталчлах зорилгоор нэгдсэн санд ирүүлж байгаа зураг, тоон мэдээлэл, тоног төхөөрөмжийн тухай танилцуулга		
		Нэгдсэн санд ирүүлж буй мэдээлэлд мета өгөгдөл бүрдүүлж өгөх	
	10 дугаар зүйл. Геодезийн байнгын цэг, тэмдэгт		
80.	10.1. Геодезийн байнгын цэг, тэмдэгт нь төрийн өмч байна.		
81.	10.2. Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлуулсан бол уг цэг, тэмдэгтийн байрлаж байгаа сум, дүүргийн Засаг даргад, хилийн зурваст бол хил хамгаалах ерөнхий газрын харьяа тусгай ангийн удирдлагад хүлээлгэж өгнө.		
82.	10.3. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна. Уг цэг, тэмдэгтийг хөдөлгөх, нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлага гарвал түүнийг сэргээн босгох зардлыг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.		

83.	10.4. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг арчлан хамгаалахад дараахь журмыг баримтална:		
84.	10.4.1. тухайн цэг, тэмдэгт байрлаж байгаа газар, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь түүнийг хамгаалах, геодезийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ;		
85.	10.4.2. нутаг дэвсгэртээ байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна;		
86.	10.4.3. хилийн зурваст байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хил хамгаалах ерөнхий газар, тухайн цэг, тэмдэгт байрлаж байгаа нутаг дэвсгэр дэх хилийн отряд хяналт тавина;		
87.	10.4.4. геодезийн байнгын цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулсан тохиолдолд Засаг дарга, хил хамгаалах ерөнхий газар нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.		
	11 дүгээр зүйл. Газар зүйн нэр		
88.	11.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хамгаалах асуудлыг сум, дүүргийн Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хамтран зохицуулна.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хэвшүүлэх асуудлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хамтран зохицуулна.
89.	11.2. Газар зүйн нэрийн жагсаалт зохиох, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, нэрийг зөв бичих, шинээр өгсөн нэр болон нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх, газрын зурагт тусгах зэрэг ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шинжлэх ухааны болон холбогдох бусад байгууллагын санал авч хэрэгжүүлнэ.		
90.	11.3. Газар зүйн нэрэнд дараахь объектын нэр хамаарна:		
91.	11.3.1. эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект;		
92.	11.3.2. хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудуу;		
93.	11.3.3. улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн доторх хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объект.		улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний доторх гудамж, талбай, байгаль, түүх соёлын дурсгалт газар, хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объект
94.	11.4. Газар зүйн хуучин нэрийг тодотгох, шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, мэргэжлийн хүмүүс, судлаачдын саналыг үндэслэн тогтооно.		
95.	11.5. Шинээр байгуулсан объектыг нэрлэхэд дараахь зарчим баримтална:		

96.	11.5.1. тухайн объектыг нээх, судлах, барьж байгуулахад оролцсон буюу эзэмшиж байгаа хүний нэрээр нэрлэх;		
97.	11.5.2. газар зүйн хуучин нэрээр нь зүг чиг, өнгө, цаг хугацааны тодотголтой нэрлэж болох;		
98.	11.5.3. ойролцоо орших өөр төрлийн объектууд нь ижил нэртэй байж болох.		
99.	11.6. Газар зүйн нэрийг дараахь онцгой тохиолдолд өөрчилж болно:		
100.	11.6.1. адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал;		
101.	11.6.2. уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан;		
102.	11.6.3. тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн байвал.		
103.	11.7. Шинээр нэрлэх, өөрчлөх газар зүйн нэр дараахь шаардлагыг хангасан байна:		
104.	11.7.1. хүрээлэн буй орчин, газар зүйн объектын тодорхой шинж, түүх, соёл, ахуйн онцлогийг тусгасан байх;		
105.	11.7.2. монгол хэлний бичлэг, хэллэгт тохиромжтой гурваас илүүгүй үгээс бүтсэн байх.		
106.	11.8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна.	Гудамж талбайд нэр өгөх өгөх асуудлыг Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12-т Хурлын Тэргүүлэгчид бүрэн эрхийн хүрээнд шийдэхээр заасан боловч УИХ-аар шийдвэрлүүлэх асуудал хүлээн зөвшөөрдөггүйгээс орхигддог.	Газар зүйн нэрийг шинээр өгөх, өөрчлөх асуудлыг Газар зүйн нэрийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн Улсын Их Хурлаар шийдвэрлүүлнэ.
			Газар зүйн нэрийн бодлогын үндэсний зөвлөл, түүний эрх хэмжээтэй холбоотой зүйл нэмэх
	12 дугаар зүйл. Хориглох үйл ажиллагаа		
107.	12.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:		
108.	12.1.2. геодезийн байнгын цэг, тэмдэгтийг устгах, гэмтээх, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулах;		
109.	12.1.3. албан ёсны баримт бичиг, арга хэмжээнд газар зүйн албан ёсны нэрийг өөрчлөн хэрэглэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглах;		
110.	12.1.4. зохих хууль тогтоомжид заасан журмыг зөрчин байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хийсэн зураг зүйн бүтээлийг хуулбарлах, олшруулах, хэвлэх.		
	13 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх		

111.	13.1. Геодезийн хэмжилт хийх, цэг, тэмдэгтийг байгуулах явцад газар, барилга байгууламж, бусад объектод учруулсан хохирлыг тухайн үйл ажиллагаа явуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлнө.		
112.	13.2. Гүйцэтгэсэн ажлын нарийвчлал, стандартын шаардлага хангагдаагүйгээс учирсан шууд хохирлын нөхөн төлбөрийг гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.		
	14 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага		
113.	14.1. Шүүгч буюу геодези, зураг зүйн улсын байцаагч геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны хариуцлага хүлээлгэнэ:		
114.	14.1.1. хэмжлийг солбицол, өндрийн улсын нэгдсэн тогтолцоонд хийгээгүй иргэнийг 10000-30000 төгрөгөөр, албан тушаалтныг 10000-40000 төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-200000 төгрөгөөр торгох;		
115.	14.1.2. энэ хуулийн 10.2-т заасныг зөрчиж шинээр байгуулсан геодезийн байнгын цэг, тэмдэгтийг зохих газарт хүлээлгэн өгөөгүй иргэнийг 10000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 20000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000 хүртэл төгрөгөөр торгох;		
116.	14.1.3. энэ хуулийн 10.3-т заасныг зөрчиж зохих зөвшөөрөлгүйгээр геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн иргэнийг 10000-40000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-50000 төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-200000 төгрөгөөр торгох;		
117.	14.1.4. геодези, зураг зүйн улсын байцаагчаас тавьсан шаардлага, хугацаатай үүргийг биелүүлээгүй, хяналт шалгалт явуулахад нь санаатайгаар саад учруулсан, эсхүл шаардагдах мэдээ баримтыг буруу гаргаж өгсөн иргэнийг 30000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 40000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000 хүртэл төгрөгөөр торгох.		
118.	14.3. Энэ хуулийн 12.1.4.-т заасныг зөрчсөн этгээдэд Зохиогчийн эрхийн тухай болон Патентын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.		
119.	14.4. Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 9.2, 10.4.1, 12.1.2-т заасныг зөрчсөн этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.		
120.	14.5. Энэ хуулийн 12.1.3-т заасныг зөрчсөн этгээдэд Газрын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.		
	<i>14 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага</i>		
121.	<i>14.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</i>		
122.	<i>14.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</i>		
			Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгийн талаар зохицуулалт нэмэх
	15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох		
123.	Энэ хуулийг 1997 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.		

Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулагдаагүй асуудал

№	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулагдаагүй харилцаа, түүнийг зохицуулах хэрэгцээ, шаардлага	Шийдвэрлэх арга зам, зүйл, заалтын томъёолол /урьдчилсан/
1	Хэмжил зураглалын ажлын хамрах хүрээг харгалзан суурь болон орон нутагт хэрэгжих гэж ангилан түүнийг гүйцэтгэх субъектийг тодорхой болгох, бүх салбарт хийгдэж буй геодези, зураг зүйн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар хянах, зөвшөөрөл олгох харилцааг зохицуулах шаардлагатай.	<ul style="list-style-type: none"> - Суурь хэмжил, зураглал o Геодезийн тулгуур сүлжээ /1-2-р ангийн бүх төрлийн сүлжээ, GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээ, тэдгээрийн цэг, тэмдэгт/ байгуулах, o Нийт нутаг дэвсгэрийг /стратегийн зориулалттай газар нутгийг/ зурагжуулах асуудал, o Улсын хилийн хэмжил, зураглал, o Томоохон гол, мөрний ёроолын зураглал, - Орон нутаг хариуцан хийх ажил o Зураглалын сүлжээ /3-4-р ангийн сүлжээ, тэдгээрийн цэг, тэмдэгт/ байгуулах, o Тухайн аймгийн тодорхой хэсгийг зурагжуулах, o 1:1000 буюу том масштабын зураглал,
2	Монгол орны нутаг дэвсгэр дээр хийж буй, хийх гэж буй ГЗЗ ажлын /байр зүйн зураг, сүлжээ, газрын зураг/ талаарх мэдээллийг бүртгэлжүүлэх /давхцуулахгүй байх арга хэмжээ авах/	Геодези, зураг зүйн үйл ажиллагааны журам боловсруулах
3	Газар зүйн нэрийн талаарх үйл ажиллагааг зохицуулах журам байхгүйгээс өөрчлөгдсөн нэр, шинээр өгсөн нэрийг баталгаажуулах үйл ажиллагаа орхигдоод байна.	Газар зүйн нэрийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батална
4	Норм, нормативын сан бүрдүүлэх	Геодези, зураг зүйн үйл ажиллагааг норм, дүрэм, техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал, стандартаар зохицуулах. Геодези, зураг зүйн ажлын төсөвт өртгийн тодорхой хувийг Геодези, зураг зүйн норм, нормативын санд төвлөрүүлэх. Геодези, зураг зүйн норм, нормативын сангийн хөрөнгөөс геодези, зураг зүйн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулахаар тусгах.
5	Бусад салбарт хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг ГЗБГЗЗГ-аас хяналт тавих боломжгүй байгаа тул Зөвлөх эсвэл мэргэжлийн холбоодоор Геодези, зураг зүйн ажилд магадлал хийлгэх боломжтой	Геодези, зураг зүйн ажилд магадлал хийх дүрэмтэй байх
6	Монгол улсад хэрэгжиж буй геодези, зураг зүйн үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгдсэн бодлого, удирдлагаар хангана.	Геодези, зураг зүйн үйл ажиллагааны журам батлах, мөрдүүлэх
7	Газар зүйн нэрийг өөрчлөх, шинээр өгөх асуудал “Газар зүйн нэрийн үндэсний зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэгдэж орон нутаг өөрсдийн дураар газар нутагт нэр өгөх, нэрлэх, нэр өөрчлөхгүй болно.	Газар зүйн нэрийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батална
9	геодези, зураг зүйн ажлын жишиг үнийг зах зээлийн жишигт нийцүүлэн, шинэчлэн гаргах, хэрэгжилтэд хяналт тавих бололцоо бий болно.	геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ батлах,

10	Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагаа нь салбарын төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны эрхлэх асуудал юм.	Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх болон мэргэшлийн зэрэг олгох журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих
11	заавар, журам боловсруулж мөрдүүлэх нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг	геодези, зураг зүйн үйл ажиллагааны журам боловсруулж батлуулах,
12	Байр зүйн зургийн шинэчлэлт, өөрчлөлт тогтмол хийгдэж байх тогтолцоо бий болгох	нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зургийн шинэчлэлт, өөрчлөлт хийх төсвийг орон нутгийн төсөвт суулган шинэчилсэн байр зүйн зургийг тухайн оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
13	Норматив баримт бичиг боловсруулах сан байхгүйн улмаас хурдацтай хөгжиж байгаа техник технологид нийцсэн бичиг баримт цаг хугацаандаа боловсруулагдаж чадахгүй байна.	Геодези, зураг зүйн үйл ажиллагааг норм, дүрэм, техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал, стандартаар зохицуулах. Геодези, зураг зүйн ажлын төсөвт өртгийн тодорхой хувийг Геодези, зураг зүйн норм, нормативын санд төвлөрүүлэх. Геодези, зураг зүйн норм, нормативын сангийн хөрөнгөөс геодези, зураг зүйн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулахаар тусгах.
14	Цэг тэмдэгтийн ангилал, нүүлгэн шилжүүлэх	Судалгааг хийж нарийвчилсан үнэлгээг шинээр гаргах.
15	Гадаадын этгээд Монгол орны нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулахдаа заавал зөвшөөрөл авах /дотоодын хамтрагчтай байх/,	
16	ГЗЗ-н нэгдсэн суурь ашиглах /орон зайн суурь мэдээлэл ашиглах/,	
17	Мета өгөгдөл зэрэг асуудлууд огт тусгагдаагүй байгааг шинээр зохицуулах шаардлагатай	
18	Мэргэшлийн зэрэг олгох, мэргэжил дээшлүүлэх асуудал	

___ оо О оо ___

Геодези, зураг зүйн тухай хуулийн бүтэц, агуулгын харьцуулсан судалгаа

д/д	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ	ОХУ-ын Геодези, зураг зүй болон орон зайн өгөгдлийн тухай, мөн зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай	БНХАУ-ЫН ХЭМЖИЛ, ЗУРАГЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ	ЯПОН УЛСЫН ХЭМЖЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл	БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ	Бүлэг I. Ерөнхий зүйл 7 зүйлтэй, 12 заалттай	Бүлэг 1 Ерөнхий зүйл
	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Зүйл 1. Холбооны улсын энэ хуулийн үйлчлэх хүрээ		Зүйл 1 Зорилго, нэр томъёоны тодорхойлолт
	2 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж	Зүйл 2. Геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үүсэх харилцааны эрх зүйн зохицуулалт		
	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо	Зүйл 3. Үндсэн ойлголт (хуулийн нэр томъёо)		
		Зүйл 4. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны субъект		
				Зүйл 2 Хэмжлийн стандарт
	ХОЁРДУГААР БҮЛЭГ Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг			
	4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа	Зүйл 5. Геодези, зураг зүйн ажил		
		Зүйл 6. ОХУ-ыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажил		
		БҮЛЭГ 2. ОХУ-д ГЕОДЕЗИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦЛИЙГ ХАНГАХ		
		Зүйл 7. Солбицлын тогтолцоо, улсын өндрийн тогтолцоо ба улсын гравиметрийн тогтолцоо	Бүлэг II. Хэмжил, зураглалын эхлэл цэг, тогтолцоо	
		Зүйл 8. Улсын геодезийн сүлжээ, улсын өндрийн сүлжээ ба улсын гравиметрийн сүлжээ	Бүлэг III. Суурь хэмжил, зураглал	Бүлэг 2 Суурь хэмжил Зүйл 1 Төлөвлөлт, гүйцэтгэл Зүйл 2 Хэмжлийн үр дүн
		Зүйл 9. Тусгай зориулалтын геодезийн сүлжээ	Бүлэг IV. Хилийн хэмжил, зураглал ба бусад хэмжил, зураглал	Бүлэг 3 Нийтийн хэмжил Зүйл 1 Төлөвлөлт, гүйцэтгэл Зүйл 2 Хэмжлийн үр дүн
				Бүлэг 4 Суурь болон Нийтийн хэмжлээс бусад хэмжил

	5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг			
	6 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үүрэг	Зүйл 21. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	Бүлэг V Хэмжил, зураглалын мэргэшилд тавигдах шаардлага	Бүлэг 5 Хэмжигч, туслах хэмжигч Бүлэг 6 Хэмжлийн компаниуд Зүйл 1 Бүртгэл Зүйл 2 Хэмжлийн үйл ажиллагаа
	7 дугаар зүйл. Санхүүжилт			
	8 дугаар зүйл. Геодези, зураг зүйн улсын хяналт	Зүйл 22. Геодези, зураг зүйн салбар дах холбооны улсын хяналт		Зүйл 3 Хяналт, шалгалт Зүйл 4 Бусад
	ГУРАВДУГААР БҮЛЭГ Бусад зүйл	БҮЛЭГ 3. ХОЛБООНЫ УЛСЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ФОНД	Бүлэг VI Хэмжил, зураглалын үр дүн	
	9 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан	Зүйл 10. Холбооны улсын орон зайн өгөгдлийн фондыг бүрдүүлэх төрөл ба онцлог		
		Зүйл 11. Холбооны улсын орон зайн өгөгдлийн фонд		
		Зүйл 12. Холбооны улсын орон зайн өгөгдлийн фонд		
		Зүйл 13. Батлан хамгаалахын орон зайн өгөгдлийн фонд		
		Зүйл 14. Орон зайн өгөгдөл (орон зайн мета өгөгдөл)-ийн тухай мэдээ мэдээлэл		
		Зүйл 15. Зураглалын ажлын үр дүнд бий болгосон материал		
		Зүйл 16. Улсын чанартай байр зүйн зураг ба план зураг		
		Зүйл 17. Тусгай зориулалтын газрын зураг		
		БҮЛЭГ 4. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АЖЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАНГАМЖ		
		Зүйл 18. Солбицлыг нь ашиглан олгох, ашиглуулах боломжтой мэдээлэл		
		Зүйл 19. Холбооны улсын ба бүс нутгийн орон зайн өгөгдлийн портал		
		Зүйл 20. Тоон зураглалын нэгдсэн суурь		

		БҮЛЭГ 5. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ		
		Зүйл 23. Зураглалын үйл ажиллагаа эрхлэх онцлог		
		Зүйл 24. Геодези, зураг зүйн ажилд тавих хязгаарлалт		
	10 дугаар зүйл. Геодезийн байнгын цэг, тэмдэгт	3.8.12-3.8.17	Бүлэг VII Геодезийн цэг, тэмдэгтийг хамгаалах	
	11 дүгээр зүйл. Газар зүйн нэр	Тусдаа хуультай		
	12 дугаар зүйл. Хориглох үйл ажиллагаа			
	13 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх			
	14 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага		Бүлэг VIII Хуулийн хариуцлага	Бүлэг 8 Хуулийн хариуцлага
		<p>БҮЛЭГ 6. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД</p> <p><u>Зүйл 25. "Газар нутгийн нэрийн тухай" Холбооны хуульд өөрчлөлт оруулах тухай</u></p> <p><u>Зүйл 27. ОХУ-ын Иргэний хуулийн дөрөвдүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай</u></p> <p><u>Зүйл 28. 2016 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 361-ФЗ тоот Холбооны хуулийг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон хүчингүй болсонд тооцсугай.</u></p> <p><u>Зүйл 29. "Төрөл бүрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Холбооны хуульд өөрчлөлт оруулах тухай</u></p> <p><u>Зүйл 30. "Үл хөдлөх хөрөнгийн төрийн бүртгэлийн тухай" Холбооны хуульд өөрчлөлт оруулах тухай</u></p> <p><u>Зүйл 31. ОХУ-ын зарим хууль тогтоомжийн бичиг баримт (хууль тогтоомжийн бичиг баримтын заалт)-ыг хүчингүй болсонд тооцох тухай</u></p>		Бүлэг 7 Устгах, хасах
	15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох	Зүйл 32. Холбооны улсын энэ хуулийг хүчин төгөлдөр болгох горим	Бүлэг IX Нэмэлт	Нэмэлт